



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 09 өдөр

Дугаар A/223

Булган сум

### "Түншлэл-хамтын ажиллагаа" зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны тэмдэглэл, Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 35 дугаар тушаал, Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7, 18.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааны хүрээнд бүс орон нутгийн онцлогтой "Хойд бүсийн түншлэл-хамтын ажиллагаа" брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, аялал жуулчлалын бүтээгдэхүүний танилцуулга арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд Булган аймгийн "Цогт хун тайжийн талбай"-д зохион байгуулсугай.

2. "Түншлэл-хамтын ажиллагаа" үзэсгэлэн, арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, үзэсгэлэн арга хэмжээний удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. "Түншлэл-хамтын ажиллагаа" үзэсгэлэн, арга хэмжээнд бүсийн аймгуудын жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, аялал жуулчлалын газруудыг бэлтгэл сайтай өргөн хүрээтэй оролцуулж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Алтаншагай)-д даалгасугай.

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА,  
ХОЙД БҮСИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2015 оны  
04 дүгээр сарын 09.-ны/ний өдрийн  
A/223. дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралт

“Хойд бүсийн түншлэл хамтын ажиллагаа” үзэсгэлэн  
арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: Д.Алтаншагай (Булган аймгийн Стандарт хэмжил зүйн  
хэлтсийн дарга)

Гишүүд: Ч.Оюун-Эрдэнэчимэг (Булган аймгийн Засаг даргын  
Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт,  
бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Үйлдвэрлэл  
үйлчилгээний салбарын бодлого хариуцсан мэргэжилтэн)

Ч.Шүрэнцэцэг (Булган аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн  
газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ж.Бат-Өлзий (Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн  
газрын дарга)

Я.Эрхэмбаяр (Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн  
газрын дарга)

М.Мөнхбат (Булган аймгийн Статистикийн хэлтсийн  
дарга)

Г.Хонгорзул (Булган аймгийн Засаг даргын Тамгын  
газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах  
албаны дарга)

Д.Бямбажаргал (Булган сумын Засаг дарга)

Н.Пүрэвсайхан (Булган аймгийн Политехникийн  
коллежийн захирал)

Г.Чимгээ (Булган аймгийн “Аялал жуулчлалын холбоо”-  
ны тэргүүн, “Монгол Алтай тур” ХХК-ийн захирал)

Д.Оюунгэрэл (Булган аймгийн Худалдаа аж үйлдвэрийн  
танхимиын дарга)

М.Ганбат (Орхон аймгийн Худалдаа аж үйлдвэрийн  
танхимиын дарга)

Д.Гэрэлтуяа (Хөвсгөл аймгийн Худалдаа аж  
үйлдвэрийн танхимиын дарга)

Нарийн бичгийн дарга: Г.Одсүрэн (Булган аймгийн Мал эмнэлгийн газрын  
дарга)

Аймгийн Засаг даргын 2025.. оны  
04. дүгээр сарын 09.-ны/ний өдрийн  
дүгээр захирамжийн 2 дугаар хавсралт

A/223

**ХОЙД БУСИЙН ТҮНШЛЭЛ-ХАМТЫН АЖИЛЛАГАА"**  
**АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР**

**1.Зорилго:** Орон нутгийн аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлж, орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг таниулах, шилдэг хоршоодыг алдаршуулах, орон нутгийн туршлага, санаачилгыг хуваалцаж, бизнес, төрийн байгууллага, төрийн бус байгууллагуудын хоорондын уялдааг сайжруулах зорилготой.

**2.Зохион байгуулалт, арга хэмжээ, хамрах хүрээ:**

2.1.Арга хэмжээ нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

2.1.1.Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг олон нийтэд танилцуулах, худалдан авах боломж олгож үзэсгэлэн, худалдааны үйл ажиллагаа.

2.1.2.Бүсийн аймгуудын аялал жуулчлалын тур оператор, жуулчны бааз, зочид буудал зэрэг аялал жуулчлалын салбарын үйлчилгээний байгууллагуудын үзэсгэлэн, танилцуулга.

2.1.3."Шинэ хоршоо-Чинээлэг малчин" хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан хоршоодын үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнийг танилцуулах үзэсгэлэн, танилцуулга

2.1.4.Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим болон түүний харьяа орон нутгийн бизнес эрхлэгч байгууллагуудын үйл ажиллагааны танилцуулга.

2.1.5.Бүсийн аймгуудын соёл урлагийн тогтолт, соёлын өв, уламжлалыг олон нийтэд танилцуулах арга хэмжээ

2.2.Тус арга хэмжээ нь өргөтгөсөн хуралдааны өмнөх өдөр болон хуралдааны өдрүүдэд 11.00-18.00 цагийн хооронд зохион байгуулагдана.

2.3.Зохион байгуулалтад тавигдах нийтлэг шаардлага: Бүсийн аймгуудын оролцоог жигд хангасан байх,

2.3.1.Бүс нутгийн байгаль, соёл уламжлалын онцлогийг шингээсэн орчин бүрдүүлсэн байх,

2.3.2.Үзэсгэлэн, арга хэмжээнд оролцогчид бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлах павильон, тайз, дэлгэцийн орчин бүрдүүлсэн байх,

2.3.3.Арга хэмжээнд оролцогчдын талбай павильоны хуваарилалтын зургийг урьдчилан гаргаж хамtran зохион байгуулагч талууд болон Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнд танилцуулах,

2.3.4.Нутгийн иргэд олон нийтэд хүртээмжтэй худалдаа, үйлчилгээ зохион байгуулах боломж бий болгох,

**3.Хамtran зохион байгуулах байгууллага: Ажлын хэсэг нь дараах байгууллагуудтай хамtran ажиллаж нэгдсэн төлөвлөгөө гаргана. Үүнд:**

- Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газар
- "Шинэ хоршоо хөдөлгөөн"

- Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ
- Экспорт ОУХТ ТББ Бусад

#### **4.Арга хэмжээний бэлтгэл хангах:**

4.1.Үзэсгэлэн арга хэмжээний хэвийн үйл ажиллагааг хангах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дараах бэлтгэл ажлыг хангана. Үүнд:

4.1.1.Оролцогч талуудын цахилгааны хэрэглээг холбох цэг, мэргэжлийн цахилгаанчин ажиллуулах,

4.1.2.Хог хаях цэг, талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, хог ачилт,

4.1.3.Орчны мэдээлэл, таних тэмдэг,

4.1.4.Авто зогсоол, замын цагдаагийн зохицуулалт,

4.1.5.Оролцогчдын эд хөрөнгийг хамгаалах хамгаалалт,

4.1.7.Галын болон эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний байгууллагын бэлэн байдал,

4.1.8.Орон нутгийн нийтийн хоолны худалдаа эрхлэгчдэд худалдаа эрхлэх талбай бэлтгэж оролцуулах,

4.1.9.Сайн дурын ажилтан бэлтгэж оролцогч талуудад туслах, орон нутгийн иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх зохион байгуулалт хийх,

#### **5.Удирдлэга, зохион байгуулалт:**

5.1.Ажлын хэсэг нь арга хэмжээний төлөвлөгөөг бусийн зөвлөлийн хурал болохоос хуанлийн 14 хоногийн өмнө Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнд (batbold.b@regional.gov.mn) цахим хаягаар хүргүүлнэ.

5.2.Арга хэмжээний төлөвлөгөөтэй Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн танилцаж хуралдааны нэгдсэн танилцуулга товхимолд оруулна.

5.3."Түншлэл-хамтын ажиллагаа" арга хэмжээний зохион байгуулалтай холбогдон гарах зардлыг бусийн зөвлөл хариуцан зохион байгуулна.